

8

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ, ЧИГ ХАНДЛАГА

Н. Батнасан

Монголчууд бид түүхт үйл явдал, өөрчлөлт шинэчлэлтээр дүүрэн хорьдугаар зуунаа үдэж, өөдрөг тэмүүлэл хүсэл эрмэлзлээ өвөрлөн гуравдахь мянганы босгыг алхлаа. Шинэ зуун бидний төсөөлж байгаагаар даяарчлал, либералчлалын эрин зуун болох шинжтэй байна. Чухам ийм үед, гараагаа эхэлж буй XXI зууны Монгол улсын эдийн засгийн хөгжил дэвшилд эдийн засгийн гадаад харилцаа, түүний дотор гадаад худалдааны салбар чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Монгол улсын экспорт, импорт цаашид ямар хэмжээнд хүртэл өсөх вэ? Гадаад худалдаа эдийн засгийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэх вэ? Гадаад худалдааны хөгжлийн ямар шинж төлөвүүд ажиглагдаж байна вэ? гэх мэт асуултуудад ямар нэгэн хэмжээгээр хариулт өгөх зорилгоор зохиогч энэхүү өгүүллийг бичиж байна.

Өнгөрсөн түүхийг эргэж харахгүйгээр ирээдүйг төсөөлөх боломжгүй. Монгол орны ойрын ирээдүйг төсөөлөн харахын тулд өнгөрсөн жилүүдэд улс орны эдийн засгийн амьдралын салаа мөчир бүхнийг хамран үргэлжилж буй шилжилтийн үеийн түүхийг эргэн харах хэрэгтэй юм. Доорхи хүснэгтэнд макро эдийн засгийн болон гадаад худалдааны зарим үндсэн үзүүлэлтүүдийн 1995-2000 оны бодит өсөлт, тэдгээрийн жилийн дундаж өсөлтийн хурдыг харуулав.

Монгол улсын макро эдийн засгийн болон гадаад худалдааны зарим үндсэн үзүүлэлтүүдийн бодит өсөлт 1995-2000 онд (1995 онтой зэрэгцүүлснээр)

үзүүлэлтүүд	1995 он	2000 он	1995-2000 оны жилийн дундаж өсөлт
ДНБ	100.00	114.95	2.8
Хөрөнгө оруулалт	100.00	175.05	11.8
Хэрэглээ	100.00	137.16	6.5
Үйлчилгээний бус экспорт	100.00	98.48	-0.3
Үйлчилгээний бус импорт	100.00	147.96	8.1

Эх сурвалж: "Монгол улсын статистикийн эмхтгэл" 1995-2000, "Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл" 1995-2000 зэрэг материалуудад тулгуурлан тооцоолов.

Хүснэгтээс харвал эдийн засгийн өсөлтийн үндсэн гол индикатор болох ДНБ-ий хэмжээ өсөх хандлагатай байгаа ба түүний өсөлтөд хөрөнгө оруулалтын өсөлт хүчтэй нөлөөлсөн байна. 1995-2000 онуудад нийт хөрөнгө оруулалтын өсөлтийн хурд ДНБ-ийхээс 4 дахин давж гарсан бөгөөд үүнийг эдийн засагт гарч буй нааштай өөрчлөлт гэж хэлж болох юм. Хөрөнгө оруулалтын өсөлтөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь улс орны үйлчилгээний бус импорт сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөхөд шууд нөлөөлсөн. Харин дотоодын нийт хэрэглээний өсөлт, аж үйлдвэрийн зарим салбаруудын үйлдвэрлэлийн уналт, түүнчлэн зэс, ноолуур гэх мэт экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн бууралт зэргээс шалтгаалан нийт экспортын хэмжээ 1995-2000 онуудад өссөнгүй, бага зэрэг буурчээ.

Хөрөнгө оруулалт, хэрэглээний өсөлтөөс шалтгаалан нийт импорт өсөөд байхад экспорт төдийлөн өсөөгүй, үүнээс үүдэн урсгал тэнцлийн алдагдал өсөн нэмэгдэх хандлага бий болоод байна. Урсгал тэнцлийн алдагдал нь ДНБ-ий өсөлтийг саатуулагч хүчин зүйл болон хувирсан байна.

Дүгнэж үзвэл, ХХ зууны төгсгөлд Монгол улсын гадаад худалдаа нь улс орны эдийн засгийн өсөлтөнд зарим талаар сөргөөр нөлөөлж байлаа.

Монгол улсын гадаад худалдаа иймэрхүү дүр зурагтайгаар дараагийн зуундаа шилжин орлоо. Шинэ зууны эхэн үед Монгол улсын гадаад худалдаа ямар төвшинд хүрч очих вэ гэсэн асуудал нь эрдэмтэд, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байгаа юм. Шинэ зууны эхэн үеийн Монгол улсын гадаад худалдааны өсөлт нь үндсэндээ доор дурдсан 4 гол хүчин зүйлээс маш хүчтэй хамаарах болно.

Үүнд:

1. Экспорт, импортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлт
2. Улс орны дотоодын нийт эрэлтийн өсөлт
3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт
4. Валютын ханшны өөрчлөлт.

Одоо эдгээр хүчин зүйлсийг авч үзье. Монгол улсын 2000 оны таваарын экспортын үнийн дүнд 34.4%-ийг зэсийн баяжмал, 16.5%-ийг ямааны самнасан ба бохир ноолуур, 41.3%-ийг нэмхэл ба нэхмэл бүтээгдэхүүн эзэлж байсан бөгөөд эдгээрийг экспортын гол нэрийн бүтээгдэхүүн гэж нэрлэж болох юм. Лондонгийн металлын бирж дээр 2000 оны 12-р сард 1 тн "А" ангилалын цэвэр зэсийн үнэ 1813 ам. долларт хүртэл өссөнөө 2001-оны 9 сарын байдлаар 1414 ам. долларт хүртэл буурав. Гэвч зэсийн үнийн уналт цааш үргэлжлээд байх уу гэдэг нь сонирхолтой асуулт юм. Салбарын олонхи мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар зэсийн үнэ өсөх магадлал өндөртэй байна. Сүүлийн жилүүдэд зэсийн үнэ унаж хуримтлагдсан нөөц багассан, нөгөөтэйгүүр зэсийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа нь ингэж үзэх шалтгаан нь болсон бололтой. Лондонгийн металлын биржийн томоохон брокер болох "Brook Hunt" пүүсийн мэргэжилтнүүд 2004 он гэхэд 3064.0 ам. долларт хүрнэ гэсэн прогнозыг хийжээ.

Монгол улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний нэг болох ноолууран бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ 2000 оны сүүл үеэс огцом уналаа. Дэлхийн зах зээл дэх ноолууран бүтээгдэхүүний томоохон нийлүүлэгч болох Монгол улсын ноолууран түүхий эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн, зах зээлд уг бүтээгдэхүүний хуримтлагдсан нөөц ихэссэн зэрэг нь ноолуурын үнийг тодорхойгүй хугацаагаар унахад хүргэв. Тэргүүлэх хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлтийн хурдац саарч байгаа нь өрнөдөд нэлээн тансаг хэрэглээний зүйлд тооцогддог ноолууран бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг бууруулж болох талтай. Энэ бүхнээс үүдэн ноолуурын үнийн энэхүү уналт цаашид ч үргэлжлэх болов уу гэсэн таамаглал дэвшүүлэхэд хүргэж байна. Гэвч хөрш БНХАУ ойрын үед ДХБ-д гишүүнээр элсвэл тэдний үйлдвэрлэгчдийн ноолууран түүхий эдийн хэрэглээ эсч, манай түүхий эдийн үнэ өсч болзошгүй. Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэл, экспортынх нь хэмжээ тасралтгүй өсч буй нэхмэл болон нэхмэлийн бүтээгдэхүүний салбарын ирээдүй нь БНХАУ ДХБ-д элсэх эсэх, түүхий эдийн үнийн өсөлт ямар хэмжээнд байх зэргээс ихээхэн хамаарах болно. Монголын экспортын гол бүтээгдэхүүний нэгд тооцогдох болсон алтны үнэ ойрын жилүүдэд нэлээд өсөх болов уу. Дэлхийн тэргүүлэх хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлтийн хурдац саарч, хөрөнгийн биржүүд дээр хувьцааны үнэ унаж байгаа нь алтанд итгэх итгэлийг улам бүр нэмэгдүүлж байгаа юм.

Дээр өгүүлсэн баримтуудаас харахад, дэлхийн зах зээл дэх манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлтийн чиг хандлага нь Монгол улсад төдийлөн ашигтайгаар өөрчлөгдөх юм байна гэсэн итгэл төрөхгүй байгаа юм.

2000 оны Монгол улсын импортын үнийн дүнд 17.9 орчим хувийг нефтийн бүтээгдэхүүн, 32.6 орчим хувийг машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл эзэлж байв. Нефтийн үнэ 2001 оны дунд үед нэлээд буурч, тогтворжих хандлагатай байсан боловч энэ 9-р сараас дахин өсч эхэллээ. Нефтийн үнийн талаар олон улсын атомын эрчим хүчний агентлаг (МАГАТЭ)-ийн мэргэжилтнүүдийн хийсэн урьдчилсан тооцоо таамаглал нь бодит байдалд зөрчигдлөө. Нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт нь түүний нийт эрэлт, нийлүүлэлтээс гадна өрнөдийн тэргүүлэх орнуудын эдийн засгийн

нөхцөл байдлаас шууд хамаарна гэдэг нь илт байна. Учир нь эдгээр орнууд эдийн засгийн нөхцөл байдлаасаа хамааран нефтийн үнийг тогтворжуулах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болох юм. Статистикийн мэдээ сэлтээс үзэхэд машин, тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгслийн дэлхийн зах зээлийн үнэ сүүлийн 30 гаруй жилд тасралтгүй өсч байгаа ба цаашид ч улам бүр өсөх болно. Энэ нь америкийн эрдэмтэн Milind M. Lele-ийн бичсэнчлэн, үйлдвэрлэлийн технологийн ялгааг бий болгоход зарцуулах зардлын хэмжээ жил ирэх тусам улам бүр өсөн нэмэгдэж байгаатай шууд холбоотой.

Дүгнэж үзвэл. XXI зууны эхэн үед манай импортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөх хандлагатай байна.

Дотоодын эрэлтийн өсөлт нь хүн амын дотоодын нийт орлогын, түүнчлэн хөрөнгө оруулалтын өсөлтөөс шууд хамаардаг. Сүүлийн 10 гаруй жилд Монгол улсын хүн амын өсөлтийн хурдац 1990-ээд оноос өмнөх үетэй харьцуулбал огцом буурсан боловч жилд дунджаар 2 орчим хувийн хурдацтайгаар тогтвортой өсч байна. Сүүлийн 5 жилд Монгол улсын ДНБ жилд 2.8 орчим хувийн хурдацтайгаар өслөө. Гадаад худалдааны үржүүлэгчдийг ашиглан ДНБ-ий өсөлтийг прогнозчлож үзвэл, энэ өсөлт нь цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Гэхдээ ДНБ-ий өсөлт нь гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай юм. Хөрөнгө оруулалтын хэмжээ ч сүүлийн жилүүдэд өндөр хурдацтайгаар өслөө. Энэ бүхэн нь Монгол улсын дотоодын нийт эрэлтийг, түүний дотор импортын эрэлтийг ойрын жилүүдэд өсгөн нэмэгдүүлэх болно. Дотоодын эрэлтийн өсөлт хэрэглээг нэмэгдүүлж, импорт өсөх хандлагыг бий болгож байна. Онолын хувьд авч үзвэл, дотоодын эрэлт өсөхөд зарим салбаруудын экспорт буурч болох талтай.

Үүнээс үзэхэд, дотоодын эрэлтийн өсөлт нь ойрын ирээдүйд төлбөрийн урсгал тэнцэлд муугаар нөлөөлөх нь зайлшгүй юм.

Монгол улсын статистикийн эмхтгэлийн тоо баримт, төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүдээс харахад нийт хөрөнгө оруулалт, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр хурдацтайгаар өсч байна. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн олон салбарт, нэн ялангуяа эрдэс түүхий эдийг олборлох, нэхмэл оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбаруудад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн. Эдгээр салбаруудад хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалт нэгэнт үр өгөөжөө өгч эхлээд байна. 1990-ээд оноос гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татаж, дорвитой хөрөнгө оруулалт хийгдэж буй оёдлын үйлдвэрүүдийн экспортын хэмжээ нь Монгол улсын нэг жилийн гадаадын шууд хөрөнгө оруулалттай дүйцэх хэмжээнд дөхөж очсон болохыг статистикийн тоо баримтууд нотолж байгаа билээ. Гэхдээ хийгдэж буй гадаадын хөрөнгө оруулалт нь хэмжээгээрээ улс орны эдийн засгийн нөөц боломжтой харьцуулахад чамлалттай, бага хэмжээнд байгааг нуух шаардлагагүй.

Өнгөрсөн зууны 90-ээд оны төгсгөлд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх

үетэй харьцуулахад хэмжээгээр эрс өссөн нь үүнийг дагалдан экспортыг нэлээд нэмэгдүүлэх болов уу гэсэн горьдлого төрүүлж байна.

Бусад валюттай харьцах төгрөгийн худалдан авах чадварын өсөлт нь импортыг нэмэгдүүлж, экспортыг бууруулдаг. Харин төгрөгийн худалдан авах чадвар буурах тохиолдолд экспорт өсч, импорт буурах ёстой. Үүний учир нь төгрөгийн бусад валюттай харьцах ханш унах тохиолдолд экспортлогчид дотоодын бусад үйлдвэрлэгчидтэй харьцуулахад бүтээгдэхүүнээ илүү өндөр үнээр гадагш борлуулах боломжтой байдаг оршино. Монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сүүлийн жилүүдэд тасралтгүй унасаар ирсэн болохыг тоо баримт харуулж байна. Сүүлийн жилүүдэд тэргүүлэх хөгжилтэй АНУ, Япон, Баруун Европын зарим томоохон орнуудын эдийн засгийн өсөлт удааширч байгаа нь тэдгээр орнуудын валютын худалдан авах чадварыг бууруулж болох талтай байгаа юм. Энэ нь Монгол улсын гадаад худалдааны тэнцэлд маш муу сөрөг нөлөөллийг үзүүлэх нь дамжиггүй. Гэхдээ гадаад худалдааны гол түнш орнууд болох ОХУ, БНХАУ-д эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэх юм бол валютын ханшны дээрх нөлөөлөл нь Монгол улсад төдийлөн хүндээр тусахгүй болов уу гэж үзэхэд хүргэж байна.

Аливаа улс орны гадаад худалдааны хөгжилтөнд нөлөөлөх асар олон тооны хүчин зүйлс бий. Үндэсний үйлдвэрлэлийн өсөлт бууралт, гадаад өр төлбөр, дотоодын зах зээл дэх өрсөлдөөний төвшин, татвар тарифийн төвшин, улсын төсвийн орлого зарлага, засгийн газрын худалдааны бодлого, байгаль цаг уурын нөхцөл байдал гэх мэт маш олон хүчин зүйлсийг энд нэрлэж болох юм. Тэр бүхнийг энэхүү өгүүлэлд багтаан авч үзэх боломжгүй бөгөөд зохиогч одоогийн нөхцөлд Монгол улсын гадаад худалдаанд хамгийн хүчтэй нөлөөлж буй зарим гол хүчин зүйлсийн талаар энд дурдсан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Шинэ зууны эхэнд улс орны гадаад худалдааны өсөлтөд эерэг нөлөөлөх хүчин зүйлс цөөнгүй байна. Хэдийгээр Монгол улсын гадаад худалдаанд дэлхийн зах зээл, гадаад орчноос үзүүлэх таагүй нөлөөлөл их байгаа боловч шинэ засгийн газраас авч хэрэгжүүлж буй худалдааны бодлого, "Монгол банк"-наас хэрэгжүүлж буй мөнгө зээлийн бодлого зэрэг нь экспортын үйлдвэрлэлийн өсөлтийг бий болгох байх гэсэн итгэл төрүүлж байна. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн өсөлт тогтворжиж, хөрөнгө оруулалт нэмэгдсэн зэрэг нь экспортын бодит өсөлтөд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй. Ойрын ирээдүйд импортын бүтцэд чанарын зарим өөрчлөлтүүд гарах болно. XXI зуун бол мэдээллийн технологийн хөгжлийн зуун юм. Үүнтэй уялдаатайгаар мэдээллийн техник хэрэгслийн импортын эзлэх хувийн жин өснө. Уул уурхай олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт, дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний хэрэглээний өсөлт зэрэг нь энэ салбар ойрын ирээдүйд экспортын тэргүүлэх салбар хэвээр байх болно гэдгийг баталж байна.